



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatcouncil@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2020.06.17 № 25

Г Асуулт тавих тухай

Танай яамнаас Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын ергетгэл, шинэчлэлийн ажлыг Азийн хөгжлийн банк /АХБ/-ны зээлийн санхүүжилттэй 5, Европын сэргээн босголт хөгжлийн банкны зээлийн санхүүжилттэй 5 нийт 10 багц хэсэг бүхий олон улсын тендер зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан хийж гүйцэтгүүлж байна. Энэхүү ажлын АХБ-ны санхүүжилттэй хэсэг 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдөр эхэлсэн ба 2020 оны 6 дугаар сард дуусахаар гэрээнд туссан боловч Короновируст халдвартын цар тахал болон бусад хүчин зүйлийн улмаас саатаж, өнөөдрийн байдлаар тус авто замын барилгын ажлын Багц 1-1, Багц 1-3, Багц 1-5 дугаар ажил дуусч, авто замыг ашиглалтад авахад бэлэн болоод байгаа мэдээллийг Та өгсөн.

Миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд тус олон улсын чанартай авто замын Багц1-1, Багц1-3, Багц 1-5 дугаар барилгын ажил болон авто замыг ашиглалтад авахтай холбогдуулан дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Багц 1-1, Багц 1-3, Багц 1-5 дугаар авто замын барилгын ажлыг батлагдсан зураг тесөл, норм, норматив, техникийн баримт бичиг, техник, технологи, эрүүл ахуй, байгаль орчны болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стандарт, чанарын шаардлагыг багц ажил тус бүр хэрхэн биелүүлж гүйцэтгэсэн талаар;
2. Дээрх багц ажлуудын еренхий гүйцэтгэгч компаниуд нь туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа Монгол Улсын аж ахуйн нэгжүүдэд хүндрэл, чирэгдэл үүсгэлгүйгээр гэрээнд заасан хугацаанд санхүүжилтийг олгодог эсэх талаар;
3. Зам барилгын ажлын Багц 1-1, Багц 1-3, Багц 1-5 дугаарт хийгдсэн авто замыг зам барилгын ажлын Багц 1-2, Багц 1-4 дугаарт хийгдэх авто замаас түрүүлж ашиглалтад авч, тус зам дундаа хоёр тасарч байгаатай холбогдуулан байгаль орчны болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг хангах хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар.

Дээрх асуултын хариут Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт зааснаар 14 хоногийн дотор бичгээр өгөх, холбогдох мэдээлэл, баримтуудыг хуулбар үнэн тэмдэг дарж хавсаргаж ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Г.ДАМДИНЯМ



2020000117